

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх
Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны
даргыг чөлөөлж, томилох тухай

Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.2, 80.4, 81 дүгээр зүйлийн 81.1, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.7, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны журмын 6.1 дэх зүйл, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны 2024 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн шийдвэр болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны даргын үүрэгт ажлаас Ердийн гишүүн Г.Уянгыг 2024 оны 6 дугаар сарын 27-ны өдрөөр тасалбар болгон чөлөөлж, Хорооны даргаар Хараат бус гишүүн Б.Солонгыг томилсугай.
2. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 2023/14-01 тоот Хороодын дарга томилох тухай тогтоолын 1 дүгээр заалтын Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороонд холбогдох хэсгийг хүчингүй болгосугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Аудитын хороо /В.Ганзориг/-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.ГАНЗОРИГ

